



***Төв аймаг дахь Төрийн адитын
газрын 2017 оны эхний хагас
жилийн үйл ажиллаганы тайлан***



Зуунмод 2017 он

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний Аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
АЗЗА	Авто зам завсар арчлалт
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
СТАУС	Санхүүгийн тйалангийн удирдлагын систем
ХОМ	Хөрөнгө орлогын мэдүүлэг
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХААГ	Хүнс, Хөдөө аж ахуйн газар
ХХААЯ	Хүнс, Хөдөө аж ахуйн яам
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 6 дугаар сарын 30

Зуунмод

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 оны эхний хагас жилд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 оны аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 бүлэг 43 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулсанаас эхний хагас жилд хийхээр төлөвлөсөн 6 бүлэг 26 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Төв аймаг дахь Төрийн аудитын газарт дарга, тэргүүлэх аудитор, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер, гүйцэтгэлийн аудитын баг, санхүүгийн тайлангийн аудитын хоёр баг, нийцлийн аудитын баг, нийлтэг үйлчилгээний албыг зохион байгуулан ажиллаж байна. 2017 онд 12 үндсэн орон тоо батлагдсаны дагуу нийт 1750 хүн/өдөр ажилласан байна.

2017 оны эхний хагас жилд 2 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, 292 санхүүгийн аудитыг хийж, 38075.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 16040.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 155.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 9501.7 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 527 зөвлөмж өгч, 101.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа. Актын барагдуулалт 64.8 хувийн биелэлттэй, албан шаардлагын хэрэгжилт 37.2 хувийн биелэлттэй байна.

Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитаар 3094.5 сая төгрөг санхүүгийн үр өгөөж тооцон бүртгэлээ. Байгууллагын төсвийн нэг төгрөгт ногдох үр өгөөж 23.1 төгрөг байна.

Хоёр. Санхүүгийн аудитын талаар

2.1 Санхүүгийн аудитын талаар

Төсвийн байгууллагууд болон ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Үндэсний аудитын газраас 2014 онд нэвтрүүлж эхэлсэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС-2) программыг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд бүрэн ашиглалаа. Санхүүгийн аудитад уг программыг ашигласнаар тодорхой хэмжээгээр цаг хугацаа хэмнэж, хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг стандартын дагуу хэрэгжүүллээ.

Сумдын соёлын төвүүд болон ТБОНӨААН-үүдийн санхүүгийн тайланд Их монгол хөлөг Аудит ХХК, сумдын эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайлан,

болон сумдын цэцэрлэгүүдийн санхүүгийн тайланд Эс Эм Аудит ХХК, зарим байгууллагуудын санхүүгийн тайланд Уваа Уул аудит ХХК нийт 109 байгууллагад гэрээний дагуу аудитыг хийж, Төрийн аудитын газрын аудитор, шинжээч нар нь бусад 183 байгууллагуудын санхүүгийн тайланд аудитыг стандарт, журам, гарын авлага, арга зүйн дагуу хийж 1344 хүн/өдөр ажиллаа.

Аудитаар 256 байгууллагад санал дүгнэлт гаргаснаас 22 байгууллага буюу 8.6 хувьд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 234 байгууллага буюу 91.4 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлттэй, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан.

Аудитаар нийт 30907.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 16040.6 сая төгрөгийн алдааг залруулж, 103.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 2283.6 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 1861.1 сая төгрөгийн зөрчилд 44 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, 10618.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар удирлагад 499 зөвлөмж хүргүүлсэн байна. Тэргүүлэх аудиторовн тушаалаар акт, албан шаардлага, зөвлөмжийг баталгаажуулан ажиллаа.

Санхүүгийн аудитаар 427.7 сая төгрөгийн үр өгөөжөөр хүлээн зөвшөөрч бүртгэлээ. Аудитын үйлчилгээний төлбөрөөр 1.7 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 26 сумын Эрүүл мэндийн төв, Баруун-Зуунмод өрхийн эмнэлэг нийт 27 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайлангийн аудитаар 26 эрүүл мэндийн төв зөрчилгүй дүгнэлт, Заамар сумын эрүүл мэндийн төв хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

Аудитаар нийт 229.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 51.3 сая төгрөгийн залруулга хийгдэж, 16.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.9 сая төгрөгийн албан шаардлага, 153.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх, хариуцлагыг сайжруулах талаар 66 зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн байна.

Боловсролын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 30 байгууллага, СӨБ-ийн 33 байгууллага, Хувийн хэвшлийн 7 цэцэрлэг, 1 сургууль нийт 71 байгууллагын санхүүгийн тайлан аудитад бүрэн хамрагдсан байна.

Ерөнхий боловсролын сургуулиудаас Өндөрширээт сумын сургуульд хязгаарлалттай санал дүгнэлт, 29 сургуульд зөрчилгүй санал дүгнэлт, 1 хувийн хэвшлийн сургууль түүвэрт хамрагдсан, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудаас Зуунмод сумын Унагалдай цэцэрлэг хязгаарлалттай санал дүгнэлт, 32 цэцэрлэгт зөрчилгүй санал дүгнэлт өгч, хувийн хэвшлийн 7 цэцэрлэг түүвэрт хамрагдсан байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3569.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2636.8 сая төгрөгийн алдааг залруулж, 22.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 31.0 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж, 879.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хариуцлагыг сайжруулах талаар 119 зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн байна.

Соёлын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн соёлын салбарын 29 байгууллагаас аймгийн Монгол туургатан театр, номын сан, музей гэсэн 3 шууд захирагчийн санхүүгийн тайланд Төрийн

аудитын газрын аудитор, шинжээч нар, 26 сумын соёлын төвийн байгууллагын санхүүгийн тайланд гэрээний дагуу Ихмонгол Хөлөг Аудит ХХК аудит хийж дүгнэлт гаргасан.

Аудитаар 29 байгууллагаас 28 шууд захирагчийн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, Монгол туургатан театрын санхүүгийн тайланд “Орлого” дансны хувьд хязгаарлалтай санал дүгнэлт өгөгдсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 219.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 181.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, зөрчлийг таслан зогсоох 1.9 сая төгрөгийн албан шаардлага бичигдсэн ба 37.5 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгөгдсөн. Соёлын салбаруудын санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар илэрсэн зөрчлийг өмнөх онтой харьцуулахад 4.7 дахин буурсан сайн үзүүлэлттэй байна.

Аймгийн Засаг даргын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Ойн анги, Орон нутгийн өмчийн газар, Санхүү хяналт, дотоод аудитын алба, Хот тохижуулах газар, аймгийн Ахмадын хороо, 26 сумын ИТХ, мөн 26 сумын ЗДТГ-ын нийт 59 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитаар нийт 19505.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 10038.3 сая төгрөгийн залруулга хийгдэж, 48.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 1720.3 сая төгрөгийн албан шаардлага, 8328.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх, хариуцлагыг сайжруулах талаар 275 зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн байна.

Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Улсын төсвийн 32 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, бүх байгууллагад зөрчилгүй санал, дүгнэлт гаргалаа.

Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн аудитаар нийт 4591.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 3414.9 сая төгрөгийн алдааг залруулж, 27.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 232.4 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 916.7 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар удирлагад 121 зөвлөмж хүргүүлсэн байна.

Төсөл сангийн санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 сумын 148 сан, аймгийн 9 сан нийт 157 тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сан, Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын харилцах дансад нь Төрийн санд, Эм эргэлтийн сангийн харилцах данс нь арилжааны банкинд байршиж үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн аудитаар аймаг, сумдын тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн даатгалын сан, Угтаал суман дахь Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангуудын санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргасан. Эдгээр дөрвөн сангийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд Төв аймгийн Чандмань ДЭХГазар, Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Жаргалант сум дах Томоко ОНӨААТҮГ Газруудын санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэн байна.

Төв аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Жаргалант сум дах Томоко ОНӨААТҮГ Газар нь 2016 онд үйл ажиллагаа явуулаагүй тул санхүүгийн тайландаа аудит хийж дүгнэлт гаргуулаагүй байна. Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Төв Чандмань ДЭХГ ОНӨҮГазрын санхүүгийн тайланд хамтран ажиллах гэрээний дагуу Ихмонгол Хөлөг Аудит ХХК аудит хийж дүгнэлт гаргасан. Санхүүгийн аудитаар Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ Газрын санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Зуунмод мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 828.4 сая төгрөгийн материаллаг алдаа илэрсэнээс 389.8 сая төгрөгийн алдааг залруулж, 20.9 сая төгрөгийн 2 алдаанд зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 417.7 сая төгрөгийн залруулаагүй алдаа болон цаашид сайжруулах 5 асуудалд зөвлөмж өгөгдсөн. 4.7 сая төгрөгийн оны эхний үлдэгдэл махыг эрх бүхий албан тушаалтны шийдвэр болон үндсэн баримтгүйгээр тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд бичилт хийн данснаас хассан зөрчлийг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Төв аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит Төв АЗЗА ХК, Эрдэнэсант АЗЗА ХК, Авдрант хайрхан ТӨААТҮГ, Баянчандмань АЗЗА ХК-иудын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргалаа. Төв АЗЗА ХК, Авдрант хайрхан ТӨААТҮГ, Баянчандмань АЗЗА ХК-иудын санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, Эрдэнэсант АЗЗА ХК-ний санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна. Төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн аудитаар нийт 2285.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 113.1 сая төгрөгийн залруулга хийгдэж, 226.1 сая төгрөгийн албан шаардлага, 1946.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх, хариуцлагыг сайжруулах талаар 19 зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагуудад нь хүргүүлсэн байна.

1.2. Төв аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Төв аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”** –д аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ноос 04 дүгээр сарын 28-ний хугацаанд хийлээ.

2016 онд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас анхны баталсан төсвийн орлого, эх үүсвэрийн төлөвлөгөөг 2 удаа өөрчлөн 69584.1 сая төгрөг болгон тодотгосон байна.

Төв аймгийн 27 сумын ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн төсвийн татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг 2434.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төв аймгийн 2016 оны төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөөг 2 удаа тодотгон 69584.1 сая төгрөгөөр баталсан байна.

2016 оны аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 15115.4 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 704.2 сая төгрөгийг хасч тооцоход 14411.2 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 112.9 хувиар буюу 1650.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 16 нэр төрлийн орлогын төлөвлөгөө биелэж, үйл ажиллагааны орлогын татвар, бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, ТТАМАТөлбөр, үндсэн хөрөнгө борлуулсны орлого, ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр, өмч хувьчлалын орлого зэрэг нь 8.8-39.0 хувиар тасарсан байна.

Төв аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 74707.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 70180.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 4529.9 сая төгрөг дутуу зарцуулсан буюу биелэлт 93.9 хувь байна. Төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 5032.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны оны эхний үлдэгдэл 77.5 сая төгрөг, тайлант онд 1914.8 сая төгрөгийн орлого орж, 1981.8 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Уг аудитаар аймгийн Засаг дарга, СТСХ-дарга, Татварын хэлтсийн дарга нарт 2 зөвлөмж хүргүүлээ.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний хагас жилд ҮАГазрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 1, аймгийн ИТХ-ын захиалгаар 1, бүгд 2 гүйцэтгэлийн аудитыг хийж нийт 399 хүн/өдөр ажиллалаа. Гүйцэтгэлийн аудитаар 18.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 6815.6 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 19 зөвлөмж өгч, 2530.0 сая төгрөгийн үр өгөөж тооцлоо.

3.1. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”**-д аудитыг 02 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 20 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэн тайлан, судалгааг ҮАГ-т хүргүүлээ.



2016 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтад 604.9 сая төгрөг батлагдсан нь нийт 3 эх үүсвэр буюу 3 сайдын багцаас санхүүжүүлэхээр батлагджээ. Үүнд: Аймгийн Засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж худалдан авахад 100.0 сая төгрөг, Зургаан Сургууль, цэцэрлэгийн барилгын их засварт 348.9 сая төгрөг, ЭМТ-ийн хоёр барилгад 156.0 сая төгрөг батлагджээ.

2016 онд орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс 3369.7 сая төгрөг батлагдсны 3241.4 сая төгрөг нь хөрөнгө оруулалт шинж чанартай ажлуудын санхүүжилт байна. Үүнээс 491.0 сая төгрөгний урд оны үлдэгдэл санхүүжилт, үлдсэн 2750.4 сая төгрөг нь 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр хэрэгжих 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилт байна. Уг аудитаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу явуулдаггүй, зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батладаг, төсөл арга хэмжээний нэр, зориулалтыг өөрчилдөг, тендерийн хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй зарцуулдаг, захиалагчаас суутган тооцох зардлуудыг суутган тооцдоггүй, захиалагчийн хяналтыг хангалтгүй тавьдаг, хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд тусгагдаггүй зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

Гүйцэтгэлийн аудитаар 18.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 1511.1 сая төгрөгийн албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 6 зөвлөмжийг аймгийн Засаг дарга, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, ГХБХБГазрын дарга нарт хүргүүлээ.

3.2 ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийж байгаа **“Идлэг шонхор шувуу барих гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль**

тогтоомжийн хэрэгжилт" сэдэвт аудитад шаардлагатай судалгааг гарган ҮАГ-т хүргүүлээ.

3.3 Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д заасны дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд төсвийн орлого нэмэгдүүлэх тооцоо, судалгаа хийн аймгийн 2017 оны төсвийн төсөлд орлогыг 1825.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх нөөц бололцоо байна гэж үзэн санал, дүгнэлтээ оруулан аймгийн ИТХ-ын "Төсвийн тодотгол батлах" тогтоолоор хүлээн зөвшөөрүүлээ.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний хагас жилд ҮАГ-аар нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 1, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, бүгд 3 нийцлийн аудитыг хийж нийт 798 хүн/өдөр ажиллалаа. Гүйцэтгэлийн аудитаар 33.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 402.5 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 9 зөвлөмж өгч, 136.8 сая төгрөгийн үр өгөөж тооцлоо.

4.1. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **"Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт"** –д аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 18-наас 05 дугаар сарын 01-ний хугацаанд хийлээ.

Аймаг, сумдын хэмжээнд 2016 онд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож 6300.9 сая төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөн баталж бүрдүүлсэн байна. Үүнээс аймагт 3323.4 сая төгрөг, суманд 2977.5 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг батласан байна. Гэвч гүйцэтгэлээр 3 суманд батлагдсан хуваариас 503.7 сая төгрөг дутуу, аймгийн ОНХС-д 503.7 сая төгрөг илүү олгожээ.

Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг холбогдох хууль, журмын дагуу тооцож бүрдүүлэн аймаг, сумын хэмжээнд 5858.0 сая төгрөгийн 244 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуудан, иргэдийн саналыг тусган хэрэгжүүлж, санхүүжилтийг олгосон байна. Зарим төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зураг, төсөв нь хийгдэж батлагдаагүй байхад ОНХС-аар төлөвлөгөөнд тусган төлөвлөн, хийж гүйцэтгүүлэх, төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байх зэрэг өмнөх жилийн зөрчил давтагдсаар байна.

Аймгийн Боловсрол соёлын газрын болон зарим сумдын удирдлагууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг хангалтгүй хийж, бэлтгэсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу зориулалт ёсоор ашиглаж, бүртгэл тайланд тусгаагүй зарим зөрчлүүд байна.

Аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байх зэрэг хууль тогтоомж зөрчсөнд 33.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 392.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, нийт 425.6 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлээ. Эдгээр зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 5 зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

5.1 Аймгийн ИТХ-ын захиалгын дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан **“Зарим төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”** /Агропарк төсөл, Хүлэмж төсөл/ сэдэвт аудитын тайланг 2017 оны 6 дүгээр сарын 20-нд дуусгаж аймгийн ХХААГ, аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нарт хүргүүлээ.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор “Агро парк төсөл”-ийн хүрээнд сум бүрт 11.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр батлагдсан боловч 9.6 сая төгрөгийн ажил хийгджээ. Энэ ажлын хүрээнд ТЭДС-аас 4.0 сая төгрөгийн бага оврын тракторын иж бүрдэл нийлүүлэхээс 1.9 сая төгрөгийн бага оврын тракторыг нийлүүлсэн нь Засгийн газрын тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.



Агро парк төслийн хүрээнд аймгийн бүх суманд хэрэгжсэн тус бүр 9.6 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-аас гэрээний үүргээ бүрэн хангасан ашиглагчдад хувьчлах шийдвэр хэрэгжээгүй байна. Аймгийн Шууд харилцаат Солонгос улсын Кангвон мужаас ХААЯ болон Төв аймгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол улсад хөдөө аж ахуйн технологи нэвтрүүлэх зорилгоор “Кангвоны хөдөө аж ахуйн хүлэмж хотхон” төслийг 3 үе шаттай хэрэгжүүлж 3 хотхон байгуулж, хэрэгжиж

дууссан байна.

Солонгос улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүлэмжийн аж ахуйн талаар иргэн, аж ахуйн нэгжтэй аймаг орон нутгийн зүгээс ямар нэгэн гэрээ, хэлцэл хийгээгүй, хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийгдээгүй байна. Аудитаар зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 5 зөвлөмжийг аймгийн ХХААГазрын даргад хүргүүлээ.

5.2 Аймгийн ИТХ-ын захиалгын дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан **“Усны тухай хуулийн хэрэгжилт”** –д гүйцэтгэлийн аудитыг 2017 оны 05 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 01-ны хугацаанд хийж байна.

2016 онд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 39.2 сая төгрөгөөр, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 384.6 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн боловч 0.84-29.8 сая төгрөгөөр 7 сум үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийг тасалдуулсан, 7 сум үйлдвэрлэлийн зориулалтаар ус огт ашигладаггүй байна.

Нийт ус ашиглагчийн 425 аж ахуйн нэгжээс чөлөөлөгдсөн 17 аж ахуйн нэгж, үйл ажиллагаа явуулаагүй 12 аж ахуй нэгж, иргэн, 132 аж ахуйн нэгж буюу 38.0 %-д ногдуулалтыг хийж, 264 аж ахуйн нэгж буюу 62.0 %-д ногдуулалт хийгээгүй байна. Ус ашигласаны төлбөрийн орлогыг 2015 онд өмнөх оноос нэмэгдүүлж төлөвлөсөн бол 2016 онд өмнөх оноос бууруулж төлөвлөсөн байна.

5.3 Аймгийн ИТХ-ын захиалгын дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан **“Газрын тухай хуулийн хэрэгжилт”** –д гүйцэтгэлийн аудитыг 2017 оны 05 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 01-ны хугацаанд хийж байна.

Аудитад аймгийн ГХБХБГазар болон 27 сумыг хамруулсан ба аудитын явцад Сэргэлэн, Зуунмод, Заамар, Угтаал, Лүн, Баянхангай зэрэг сумдад ажилласан. Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017.01.13-ний өдрийн 02 тоот тогтоолоор аймгийн Газрын нэгдмэл сангийн 2016 оны тайланг хэлэлцэн баталгаажуулсан байна. Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн



байдлаар өссөн дүнгээр 43654 иргэнд 10423.7 га газрыг өмчлүүлсэн, 27459 иргэн 1983 аж ахуйн нэгж байгууллагад 388274.14 га газрыг эзэмшүүлж, 53 байгууллага 6896.7 га газрыг ашиглаж байна. Аудитын газраас 2014 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар Газрын тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг зөрчин дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр 2003 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш үнэ төлбөргүйгээр эзэмшүүлсэн газраас тухайн үед мөрдөгдөж байсан аргачлалын дагуу 27 сумаар эзэмшигч бүрээр тооцооллыг хийж 11171.4 сая төгрөг аймгийн төсөвт төвлөрөх боломжтой байгааг тогтоосон. ГХБХБГазрын газрын дуудлага худалдааны анхны үнийг төвлөрүүлсэн мэдээ судалгаагаар 2014 онд 496.8 сая төгрөг, 2015 онд 311.1 сая төгрөг, 2016 онд 94.1 сая төгрөг төвлөрүүлсэн нь 2014-2016 онуудад дуудлага худалдааны анхны үнэ төвлөрүүлэх талаар хангалтгүй ажилласан байна. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2015 онд 161.3 сая төгрөгөөр буюу 110.3 хувиар, 2016 онд 176.6 сая төгрөгөөр буюу 111.9 хувиар, 2017 оны эхний 5 сарын байдлаар 23.7 сая төгрөгөөр буюу 104.0 хувиар давуулан биелүүлсэн.

Зургаа. Дотоод ажлын талаар

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны сургалт, семинар, зөвлөгөөн 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд болж Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал, аудитын менежер О.Амаржаргал нар оролцлоо.

Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС-2) программыг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашиглаж орон нутаг дахь төрийн аудитын байгууллагуудаа манлайлан тодорхой хэмжээгээр цаг хугацаа хэмнэж, хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг стандартын дагуу хэрэгжүүллээ.

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч, ХОМ-ийн тайланг Авлигатай тэмцэх тухай хуулийн дагуу 02 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т хүргүүлэв.

Авилгын эсрэг хууль тогтоомжийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан сурталчилж, Аудит эхлэх тухай бүрт ашиг сонирхолын зөрчилгүй тухай мэдэгдэлийг ажилтнуудаар гаргуулан гарын үсэг зуруулж баталгаажуулан ажиллаж байна.

Байгууллагын бүтэц зохион байгуулалтанд өөрлөлт орсонтой холбогдуулан шинээр томилогдох даргын хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг хугацаанд нь гаргуулж Авлигатай тэмцэх газраар хянуулан Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Нууцын бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, нууцын тэмдэг, хадгалах сейф, тусдаа сүлжээнд холбогдоогүй компьютер ашиглаж байна. Төрийн нууцын жагсаалт, зэрэглэлд хамрагдах мэдээ, баримт бичигт нууцын баталгаа гарган ажиллаж байна.

2017 оны эхний хагас жилд иргэд, байгууллагаас 4 өргөдөл, санал хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд шалган хариуг албан ёсоор хүргүүллээ. Хариутай бичиг 26 ирснээс хугацаа болоогүй 3 бусад нь хугацаандаа шийдвэрлэгдсэн. Аудитын тайланг хувиан олшруулж 296 албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгүүдийн дагуу шаардлагатай мэдээ, судалгааг гарган хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

Улирал бүр статистик мэдээ гарган аймгийн Статистикийн хэлтэст, хагас жилээр статистик мэдээ, үйл ажиллагааны тайлан гарган ҮАГазар хүргүүлэн ажиллалаа. Долоо хоног бүрийн 5 дах өдөр Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын болон үйл ажиллагааны явцын мэдээллийг ҮАГ-т хүргүүлж ажиллаа.

292 санхүүгийн тайлангийн аудит, 1 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар 2 аудитын үе шат бүрт чанарын хяналтыг хийж, чанарын хяналтын хуудсыг хөтөллөө. Гэрээт аудитын компаниудын санхүүгийн аудит, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хуулийн үндэслэлд хяналт тавьж ажилласан.



СТАУС-2 программыг ашиглах, өөрчлөлт тохируулгын ажлын талаар Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Батсайхан, SMART GREEN ХХК-ны ажилтан нар Төв аймгийн аудитын газрын ажилтнуудад сургалтыг 2017.01.25-ний өдөр явууллаа. Уг сургалтаар программын сайжруулалтын талаар харилцан ярилцлаа.

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь www.audit.mn веб сайтаар 2017 онд хийсэн бүх аудитын тайлан, дүгнэлтийг байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

ҮАГ-тай нэгдсэн сүлжээнд холбогдсноор зохион байгуулсан онлайн хуралд бүрэн оролцож, мэдээ тайланг шуурхай хүргэн ажиллаж байна. “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар”, “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “Нэгдсэн төсвийн гүйцэтгэл” зэрэг аудитын явц, дүнгийн талаарх мэдээлэл солилцох онлайн хурал, сургалтанд давхардсан тоогоор 16 ажилтан хамрагдлаа.

2017.03.15-нд зохион байгуулагдсан аймаг, сумдын төсвийн нягтлан бодогч нарын сургалтын үеээр СТАУС-2 программын танилцуулга болон санхүүгийн тайлангийн аудит хийлгэхэд анхаарах асуудал сэдвээр, Мөн 2017.05.12-нд аймаг, сумдын төсвийн нягтлан бодогч нар, санхүүгийн ажилтнуудын сургалт, семинарын үеэр 2017 оны санхүүгийн аудитын дүнгийн талаар аудитын менежер мэдээлэл хийлээ.

Аймгийн СТСХ, ММНБИ-ийн Төв аймгийн салбар, Төв аймаг дахь Төрийн аудитын газраас хамтран Нярав, эд хариуцагчийн сургалтыг 2017.05.25-наас 3 хоног зохион байгууллаа. Сургалтанд аймгийн төв, сумдын 40 гаруй нярав, эд хариуцагч хамраглаа.

Эрсдлийн аудитын журмын төсөл, дотоод журам, ажлын байрны тодорхойлолтын төсөлд саналаа хугацаанд нь өглөө.

Төв аймаг дахь төрийн аудитын газар нь 2017.01.06-нд Төр захиргааны 2 дугаар байранд нүүж, тохижилтийг хийсэн.

ҮАГ-аас зохион байгуулсан “Сонсох” ажиллагаанд хоёр удаа хамрагдсан. МУЕА-ын 2017.05.26-ны Б/170 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн аудитын газрын 12 албан хаагчдыг албан тушаалаас нь чөлөөлж, хоёрдугаар хавсралтаар Төв аймаг дахь Төрийн аудитын газрын мэдэлд 10 албан хаагчдыг авсан байна. Төв аймаг дахь Төрийн аудитын газрын албан хаагчдыг буцаан томилох тушаал гараагүй байна.

Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор аудитын менежер, аудитор, шинжээч нартай үр дүнгийн гэрээ байгуулаагүй тул эхний хагас жилд биелэлтийг тооцоогүй байна.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

2017 оны эхний хагас жилд Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 133.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас сар бүрийн хуваарийн дагуу 132.3 сая төгрөгийн санхүүжилт авч, үүнээс цалин шимтгэлд 114.8 сая төгрөг, хангамжийн материалд

3.8 сая төгрөг, томилолт 3.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил буюу үйлчилгээний ажилчдын цалин, бусад татвар хураамжид 9.6 сая төгрөг, бусад зардалд 0.9 сая төгрөг зарцуулж, 1.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эхний хагас жилд цалингийн зардал хүрэлцээгүйгээс НДШ-д 4.5 сая төгрөгийн өглөгтэй гараад байна.

Байгууллагын санхүүгийн сар бүрийн мэдээг дараа сарын 2-ны дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны дотор дээд шатны байгууллагад хүргүүлэн баталгаажуулан нэгтгүүлж байна. Байгууллагын санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд Шилэн дансны нэгдсэн вэб сайт болон Үндэсний аудитын газрын вэб сайт, байгууллагын самбарт мэдээллэж ажиллаа.

Байгууллагын 2017 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар томилсон тооллогын комисс хугацаанд хийж гүйцэтгэлээ. Тооллогын комиссийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт, актлах хөрөнгийн жагсаалтыг ҮАГ-ын Тамгын газарт хүргүүлээ.

Найм. Дүгнэлт санал

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 оны эхний хагас жилд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Төв аймаг дахь Төрийн аудитын газарт дарга, тэргүүлэх аудитор, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер, гүйцэтгэлийн аудитын баг, санхүүгийн тайлангийн аудитын хоёр баг, нийцлийн аудитын баг, нийлтэг үйлчилгээний албыг зохион байгуулан ажиллаж байна.

2017 оны эхний хагас жилд Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 133.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас сар бүрийн хуваарийн дагуу 132.3 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

2017 оны эхний хагас жилд 2 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, 292 санхүүгийн аудитыг хийж, 38075.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 16040.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 155.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 9501.7 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 527 зөвлөмж өгч, 101.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа. Актын барагдуулалт 64.8 хувийн биелэлттэй, албан шаардлагын хэрэгжилт 37.2 хувийн биелэлттэй байна.

Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитаар 3094.5 сая төгрөг санхүүгийн үр өгөөж тооцон бүртгэлээ. Байгууллагын төсвийн нэг төгрөгт ногдох үр өгөөж 23.1 төгрөг байна.

Эхний хагас жилийн байдлаар үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасаны дагуу 6 бүлэг 26 арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллалаа.

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР